



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.2 дахь хэсэг нэмсүгэй:

“14.2.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг авна.”

**2 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийн 11<sup>1.1.7</sup> дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР